



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 564

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 11 нэрийн нийт 162,600,725.00 (нэг зуун жаран хоёр сая зургаан зуун мянга долоон зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Акталсан, сэлбэгээр худалдсан автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
564 дугаар тогтоолын хавсралт



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (мян.км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1.407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги				
1	Асио автобус 76-15 УНН /арал KN2DAM2C1XK005908, хөдөлгүүр 514581/	2011	270	15,000,000.00
2	Киа трейд 77-40 УНЗ /арал KN3JAP3S6YK109519/	2010	228	8,004,000.00
	Дүн			23,004,000.00
2.409 дүгээр хаалттай хорих анги				
3	Фургон 20-59 УНЦ /арал 374100A0420660, хөдөлгүүр 0002242/	2010	163	18,100,000.00
4	Тоёота бероса 36-98 УБЗ /арал JCG100062600, хөдөлгүүр 2490/	2013	227	16,408,000.00
	Дүн			34,508,000.00
3.Хэнтий аймаг дахь ШШГГ-419 дүгээр нээлттэй хорих анги				
5	Зил-130, 30-75 ХЭҮ /арал 2729813, хөдөлгүүр 687522/	1988	312	650,000.00
6	Делика 00-35 ХЭА /арал PE8W-00105339/	2010	256	5,000,000.00
	Дүн			5,650,000.00
4.Багануур дүүрэг дэх ШШГХ-427 дугаар хаалттай хорих анги				
7	Бохирын машин 49-42 БРА /арал 258178, хөдөлгүүр 814678/	2002	252	9,600,000.00
	Дүн			9,600,000.00
5.439 дүгээр хаалттай хорих анги				
8	Мотоцикл	2013	-	1,200,000.00
	Дүн			1,200,000.00
6.Багануур-Тоосго ТӨААТҮГ				
9	Чиргүүл	1985		32,400.00

	Дүн			32,400.00
7.421 дүгээр нээлттэй хорих анги				
10	Тоёота короса 22-97 УБИ /арал EL530311469, хөдөлгүүр 4713054/	2007	241	5,000,000.00
	Дүн			5,000,000.00
8.435 дугаар хаалттай хорих анги				
11	Ландкрузер-80 39-06 ДАР /арал FZJ800050535/	2008	323	17,419,500.00
	Дүн			17,419,500.00
9.439 дүгээр хаалттай хорих анги				
12	Фургон 10-58 ТӨА /арал 374100B0442217, хөдөлгүүр B0000533/	2011	186	19,200,000.00
	Дүн			19,200,000.00
10.Хөвсгөл аймаг дахь ШШГГ				
13	Фургон 39-82 ХӨВ /арал 374100a0420820/	2010	350	18,100,000.00
	Дүн			18,100,000.00
11.Булган аймаг дахь ШШГГ				
14	Ландкрузер-80 63-80 УБЗ /арал FZJ800079585/	2012	201	28,886,825.00
	Дүн			28,886,825.00
	Нийт дүн			162,600,725.00 (нэг зуун жаран хоёр сая зургаан зуун мянга долоон зуун хорин таван)